



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/10

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Ухаалаг худаг /Жаргалант сум, 320 айлын сууршлын бүс/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Мөнх-Очир - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Г.Нэргүй - Онцгой байдлын газрын дэд дарга  
Ц.Нямбаяр - Төрийн бус байгууллагын төлөөлөл  
М.Төрхүү - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Сонинтуяа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /С.Мөнх-Очир/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Сонинтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД